

ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ

“Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, иргэний төлөөлөл бүхий орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байна.”

Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.

НИЙСЛЭЛ БОЛОН 19 АЙМАГТ*

НИЙТ **20**
ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ (ИЗ)
АЖИЛЛАЖ БАЙНА



ИЗ-д нийт **104** гишүүн ажиллаж байна.



23-75 насны гишүүдийн **66%** нь эрэгтэй **34%** нь эмэгтэй.



ИЗ-ийн дарга 1-3 жилээр томилогддог.

ДАРГА

* Төсөвгүйн улмаас Архангай, Сэлэнгэ аймагт ИЗ ажилладаггүй

АЖЛЫН НӨХЦӨЛ



ТӨСӨВ

11 ИЗ үйл ажиллагаа явуулах төсөвтэй.



АЛБАН ӨРӨӨ

7 ИЗ албан өрөөтэй.
7 ИЗ Иргэний танхимд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус танхимд хуваарьт ажил гарах үед өрөөгүй болдог.
5 ИЗ албан өрөөгүй.



СУРГАЛТ

ИЗ-ийн **104** гишүүнээс **73** гишүүн буюу **70%** нь дор хаяж нэг удаа сургалтад хамрагдсан.



АЛБАН БЛАНК

11 ИЗ албан бланктай.



ТЭМДЭГ

5 ИЗ тэмдэгтэй.

УРАМШУУЛАЛ




ИЗ-ийн гишүүдийн урамшууллыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл орон нутгийн төсөв, Засаг даргын нөөц сан зэргээс аймаг бүр өөрийн онцлогт тохируулан олгож байна.

2017

Мониторингийн дүнгээр **11** ИЗ-ийн гишүүдэд урамшуулал олгожээ.

ИЗ-ийн гишүүдийн урамшуулал **50'000 - 240'000** төгрөгийн хооронд ялгамжтай байна.

Нийслэл ба аймгуудын урамшууллын хэмжээ



А. ХУРАЛ



Хурал

Өнгөрсөн хугацаанд 18 ИЗ хурлаа хийснээс 70 хувь нь жилд дунджаар 5-10 удаа хуралджээ. Говьсүмбэр аймгийн ИЗ хурлаа нэг ч удаа хийгээгүй.

Тэмдэглэл

12 ИЗ хурлын тэмдэглэл хөтөлдөг.

Дэг

9 ИЗ хурлын дэгтэй.

Хөндлөнгийн шинжилгээ

Нийт 10 ИЗ Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон олон нийтэд үйл ажиллагаагаа тайлагнасан. Дархан-Уул, Орхон аймгийн ИЗ ажлын тайландаа хөндлөнгийн шинжилгээ хийлгэсэн.

Б. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ



5 Дархан-Уул, Завхан, Орхон, Төв, Увс зэрэг таван аймгийн ИЗ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурал эсхүл Цагдаагийн газрын цахим хуудаст мэдээллээ байршуулдаг.


3 Дархан-Уул, Орхон, Төв зэрэг гурван аймгийн ИЗ фэйсбүүк хуудсаараа дамжуулан мэдээлэл түгээдэг.

2 Говь-Алтай аймгийн ИЗ суурин болон явуулын саналын хайрцаг ажиллуулдаг. Завхан аймгийн ИЗ Цагдаагийн газарт саналын хайрцаг байрлуулж санал авдаг.


- ИЗ-ийн үйл ажиллагааны үр дүнд Говь-Алтай аймагт стандартад нийцсэн эрүүлжүүлэх байр ашиглалтад орж байгаа, мөн хөршийн холбоо байгуулснаар хулгайн хэрэг буурсан.
- Завхан аймгийн Улиастай хотыг камержуулсан.
- ИЗ-ийн тухай нэгтгэсэн “Орхон аймаг дахь Иргэний зөвлөл” ном хэвлэгдэн гарсан.
- Өмнөговь аймгийн Цагдаагийн газарт “Иргэдийг хүлээн авах танхим” байгуулах саналыг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тавьж, 50 сая төгрөгийг төсөвт суулгаж шийдүүлсэн.

ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Үйл ажиллагаа явуулахад учирч буй хамгийн гол бэрхшээл нь урамшуулал, төсөв хүрэлцээгүй байдал, дэмжлэг бага байх явдал.



УРАМШУУЛАЛ, ТӨСӨВ БАГА



ДЭМЖЛЭГ БАГА

Тодруулбал:

- Урамшуулал бага тул идэвх сул.
- Ажлын байр, тоног төхөөрөмж хангалтгүй.
- Ажлын арга зүй, үр чадвар дутмаг.
- Томилолт, унаа шатахууны төсөв хүрэлцдэггүй.
- Нэгдсэн удирдлага байхгүй.
- Сургалт хэрэгцээ шаардлагад нийцдэггүй.
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дэмжлэг сул.
- Гишүүний сонгон шалгаруулалтыг дүрмийн дагуу явуулдаггүй.

ДҮРЭМД ОРУУЛАХ САНАЛ

15 ИЗ-ээс дүрэмд оруулахаар өгсөн саналыг бүлэглэн харуулбал:

- | | |
|--|--|
| Төсвийг шийдэх | Дүрмийг боловсронгуй болгох |
| Албан бланк, тэмдэгтэй байх тухай тусгах | ИЗ-ийг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийг тодорхой заах |
| Гишүүдэд тавигдах шаардлагыг өөрчлөх | Даргыг орон тооны болгох |
| Гишүүдийг чадавхжуулах сургалтыг тодорхой тусгах | Унаа, шатахууны асуудлыг шийдэх |